

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/47

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, 29.1.2./б/ дэх заалт, Аймгийн 2021-2025 оны Үндсэн чиглэлийн 2.5.3 дахь заалт, 2.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор аймгийн 80 жилийн ойг угтан аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цаашид ямар арга хэмжээ авах талаар төлөвлөх, зураглал гаргаж дүгнэлт гаргах, шинээр нэмэгдүүлэх болон засварлах ажлын зураг төсвийг хийлгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Б.Намуун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: С.Байгалмаа – Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Энхжаргал – Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

О.Эрдэнэ-Оюун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Хүрэлхуяг – Аймгийн Ерөнхий архитектор

Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

О.Байгалмаа – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой хариуцсан мэргэжилтэн

Н.Пүрэвжаргал – Баянхонгор сумын Захирагчийн ажлын албаны дарга

С.Бурмаа – Баянхонгор сумын агаар, хөрсний орчны бохирдол хариуцсан ажилтан

Д.Ганаа – Хот тохижилт Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

1213116


2.

П.Уртнасан – Сум дундын ойн ангийн дарга

2. Баянхонгор аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цаашид ямар арга хэмжээ авах талаар төлөвлөх, зураглал гаргаж дүгнэлт гаргах, шинээр нэмэгдүүлэх болон засварлах ажлын зураг төсвийг хийлгэх” ажлын хэсгийн тайланг 01 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг /Л.Хишигбаатар/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН